

ГИПСЭН ХАНА НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

.... оны ... дугаар сарын

№

Улаанбаатар хот

Нэг талаас: “.....” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/, Нөгөө талаас: “.....” ХХК /цаашид “Худалдан авагч гэх, хамтад нь “Талууд” гэх/ нар Иргэний хууль болон Барилгын хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрэн доор дурдсан зүйлийг харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь чанарын өндөр үзүүлэлт бүхий, дэлхийн болон монголын зах зээл дээр хэрэглэгчдэд танил болсон бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, борлуулах, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2 Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь бүтээгдэхүүнийг энэхүү гэрээний Хавсралтад заасан тоо хэмжээний дагуу, худалдан авагчийн мэдээлсэн цаг хугацаанд нийлүүлэх үүргийг тус тус хүлээнэ.
- 1.3 Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол улсын хууль тогтоомж, гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.
- 1.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай саналаа бичгээр гаргана.
- 1.5 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Хоёр. Гэрээт ажил

- 2.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэнээр дуусгавар болно.
- 2.2 Гэрээний хугацааг талууд харилцан тохиролцсоноор сунгаж болно.
- 2.3 Худалдан авагчийн урьдчилан тооцоолсон худалдан авах бараа материалын тоо хэмжээг энэхүү гэрээний Хавсралт 1-ээр батлав.
- 2.4 Худалдан авагчийн бараа материалын татан авалт нь Захиалгын хуудсанд үндэслэнэ.
- 2.5 Гэрээт ажлын хүрээнд худалдан авагч нь өөрийн барилга угсралтын ажилд шаардлагатай хэмжээгээр захиалга өгөх бөгөөд захиалга өгснөөс хойш 10 хоногийн дотор нийлүүлэгч нь худалдан авагчийн барилгын талбай дээр захиалсан бараа материалыг тээвэрлэн хүргэнэ.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Энэхүү гэрээний нэгж үнэ нь ₮ (.....) төгрөг ба урьдчилан тооцоолсон бараа материалын тоо хэмжээнд үндэслэн гэрээний нийт үнэ нь төгрөг байна. Энэхүү гэрээний нэгж үнэ нь нэмэлт бараа материалын захиалга өгсөн эсэхээс үл хамааран өөрчлөгдөхгүй болохыг үүгээр баталж байна.
- 3.2 Худалдан авагч нь тохиролцсон бараа материалаас гадна нэмэлтээр захиалга өгөх эсхүл илүү гарсан бараа материалыг энэхүү гэрээний үнээр буцаан нийлүүлэгчид худалдаж болно.
- 3.3 Гэрээний үнэнд гэрээнд заагдсан барааны НӨАТ-ын үнэ болон бараа материалын гаалийн зардал, тээврийн зардал орсон болно.

- 3.4 Гэрээний төлбөр нь захиалгын хуудсанд үндэслэх бөгөөд бараа материал барилгын талбайд бууснаас хойш ажлын 1 хоногт багтаан захиалсан бараа материалын үнийн дүнгээр Нийлүүлэгчийн..... тоот дансанд 100% бүрэн төлнө.
- 3.5 Гэрээний үлдэгдэл төлбөрөөс чанарын баталгаат хугацаанд нийт гэрээний үнийн дүнгийн 5%-тай тэнцэх хэмжээний дүн болох төгрөгийг худалдан авагч барьж үлдэх бөгөөд чанарын баталгаат хугацаа дуусгавар болсноос хойш 3 хоногийн дотор Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Чанарын баталгаа

- 4.1 Нийлүүлэгч нь өөрийн нийлүүлсэн бараандаа чанарын баталгааг гаргаж өгөх бөгөөд баталгаат хугацаа нь барилгыг улсын комист хүлээлгэх хүртэл хугацаанд үргэлжилнэ.
- 4.2 Баталгаат хугацаанд дараахь тохиолдлуудын улмаас барааны чанарт гарсан гэмтлийг Нийлүүлэгч хариуцахгүй. Үүнд:
- 4.2.1 Чийгний норматив хэмжээ хэтэрсэнээс үүдэлтэй гэмтэл
 - 4.2.2 Галын аюулаас үүдэлтэй гэмтэл
 - 4.2.3 Механик гэмтэл /санаатай ба санамсаргүй/
 - 4.2.4 Угсралтын технологийн горим баримтлаагүй
 - 4.2.5 Зориулалтын бус дагалдах материал ашигласан
 - 4.2.6 Зориулалтын бусаар ашигласан
 - 4.2.7 Ашиглалтын буруугаас болон инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдсанаас үүдэлтэй гэмтэлүүд
- 4.3 Энэхүү гэрээний нөхцлийн дагуу нийлүүлж байгаа бараа нь захиалагчийн хүсэлт болон чанар, стандартын шаардлагад бүрэн нийцсэн, аливаа доголдолгүй байна.
- 4.4 Нийлүүлэгч өөрийн нийлүүлсэн барааны чанарыг сорилын гэрчилгээ болон тохирлын гэрчилгээгээр батлан тодорхойлно.
- 4.5 Талууд барааг хүлээлцэхдээ нийлүүлж байгаа барааны тоо, хэмжээ, чанар стандартын шаардлага хангасан эсэхийг шалгаж хүлээлцэн, акт үйлдэнэ.

Тав. Худалдан авагчийн эрх, үүрэг

- 5.1 Уг гэрээний 3.3; 3.4 заалтуудын дагуу хугацаандаа төлбөрөө төлөх үүрэгтэй.
- 5.2 Гэрээний хавсралтад заагдсан барааг тоо хэмжээгээр хугацаанд нь нийлүүлэхийг шаардах эрхтэй.
- 5.3 Нийлүүлэгчийн нийлүүлсэн бараанд баталгаат хугацааны дотор худалдан авагчийн буруутай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд чанарын доголдол илэрсэн барааг буцаах, солиулах эрхтэй.
- 5.4 Бараа материал барилгын талбай дээр ирсэн тохиолдолд бараа материалыг өөрийн талбай буулгах, зөөх үүрэгтэй.
- 5.5 Өөрт шаардлагатай бараа материалыг тухай бүр нь захиалж, нийлүүлэгчид боломжит хугацаанд мэдэгдэх үүрэгтэй

Зургаа . Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 6.1 Худалдан авагчийг гэрээнд заасан хугацаанд гэрээний үнийн дүнгийн тооцоог хийхийг шаардах эрхтэй.

- 6.2 Гэрээний төлбөр төлөлт хугацаандаа хийгдээгүй үед бараа нийлүүлэлтийг тухайн нөхцөл байдал арилах хүртэл түр зогсоох эрхтэй.
- 6.3 Худалдан авагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд өөрт учирсан хохирлоо нөхөн төлөхийг шаардах эрхтэй.
- 6.4 Чанарын шаардлага хангасан, гэрээний хавсралтуудад заасан бараа материалыг Худалдан авагчид актаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 6.5 Баталгаат хугацааны дотор барааны чанарын талаар Худалдан авагчаас гаргасан гомдлыг хүлээн авч чанарын доголдол илэрсэн тохиолдолд барааг буцаах, сольж өгөх үүрэгтэй.
- 6.6 Барилгын явцад анх тооцолсноос нийлүүлсэн бараа илүү гарсан тохиолдолд 2 талаас комисс томилж бүтээгдэхүүн нь анхны шинж чанараа алдаагүй, хэлбэрт өөрчлөлт ороогүйг тогтоож тус барааг 1 сарын дотор буцаан авах үүрэгтэй.
- 6.7 Худалдан авагчийн захиалсан хэмжээгээр өөрийн машинд ачиж, худалдан авагчийн барилгын талбай хүртэл тээвэрлэх үүрэгтэй.

Долоо. Хариуцлага

- 7.1 Талууд өөрийн буруутай үйл ажиллагаанаас нөгөө талдаа хохирол учруулсан бол нөхөн төлөх үүрэгтэй.
- 7.2 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алдангийг нөгөө талдаа төлнө.
- 7.3 Захиалга өгсөн өдрөөс эхлэн нийлүүлэгч тал 10 хоногт багтаан барааг өөрийн агуулах дээр бэлэн байлгана.
- 7.4 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдсэн ба тэдгээр нь хууль зүйн хувьд адил хүчин чадалтай байна.
- 7.5 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гарын үсэг зурж баталгаажуулснаар нэмэлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

Найм. Бусад

- 8.1 Гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэгэнд хохирол учиран тохиолдолд нөгөө тал өөрийн буруугүйг нотолсон тохиолдолд хариуцлага хүлээхгүй.
- 8.2 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн дэргэдэх Барилга, Дэд бүтцийн Олон Улсын Арбитраар түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдан авагч талыг төлөөлж:

Бэлтгэн нийлүүлэгч талыг төлөөлж:

.....

.....